



НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Сахилга дэг журмыг сайжруулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 258 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн "Дүрэм батлах тухай" 33 дугаар тогтоол, Байгууллагын дүрмийн 2.6.3, 2.6.7, 2.6.9 заалтууд, Амаржих газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн "Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалт тарифийг шинэчлэн батлах тухай" А/67 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалтад ороогүй эмчилгээ, үйлчилгээнээс төлбөр авахыг нийт эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудад хориглосугай.

2. Ажлын хариуцлага, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх, эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнуудын үйл ажиллагаанд байнгын хяналт тавин ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулах, холбогдох тушаал, шийдвэр, дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /А.Дүүрэнбилэг/, Дотоод хяналт шалгалт эрхэлсэн ажилтан /Ц.Мөнхцэцэг/, Хүний нөөцийн алба /Ж.Дэлгэрцэцэг/, Чанарын алба /С.Мөнхзул/, Сувилахуйн алба /Л.Амаржаргал/, Халдварын сэргийлэлт хяналтын алба /Т.Энхбаатар/ Тасгийн эрхлэгч нар, бүх алба, хариуцлагатнуудад,

3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээг сахиулах ажлыг эрчимжүүлэхийг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хороо /С.Алтантуяа/-д,

4. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахин эмнэлгийн тусламж үйлчилгээнд мөрдөгдөх стандарт, хөдөлмөрийн дотоод журам, холбогдох бусад дүрэм журмыг чанд мөрдөж, ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг чанартай хийж гүйцэтгэхийг нийт эрүүл мэндийн ажилтнуудад тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллахыг Дотоод хяналт шалгалт эрхэлсэн ажилтан /Ц.Мөнхцэцэг/-т даалгасугай.

ДАРГА  Г.БАЯСГАЛАН



